



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/567

Хэрлэн сум

Хөрөнгө оруулалтын чуулган зохион  
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуй нэгж байгууллагыг дэмжиж, хамтран ажиллах, Хэнтий аймагт төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, бизнес эрхлэх боломжуудыг танилцуулж, гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, аймаг болон бүс нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор “Инвест Хэнтий 2023” хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулахад 24,471,500 (хорин дөрвөн сая дөрвөн зуун далан нэгэн мянга таван зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Нөөц сангийн шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны.....дугаар сарын.....-ны  
A/567.....дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГАНЫ  
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт дүн ₮
1	Тайз засалт, хэвлэмэл материалын үйлчилгээ	хүн/өдөр	1	15 891 500	15 891 500
2	Гадна босоо туг	ш	6	180 000	1 080 000
3	Түүхэн аялал жуулчлалыг хөрөнгө оруулагчдад сурталчлах танилцуулга брошур	ш	600	12500	7 500 000
	<b>Нийт дүн</b>				<b>24 471 500</b>